

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2020 оны 4 дүгээр сарын 08, 23-ны өдөр 2 удаа хуралдаж өмчийн тухай, шагналын тухай, УИХ-ын сонгуулийг зохион байгуулах аймгийн хорооны бүрэлдэхүүнийг батлуулах саналыг Сонгуулийн ерөнхий хороонд уламжлах тухай, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтын зардлын тухай, Булган уулыг дархан цаазат газар болгох саналыг уламжлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны УИХ, орон нутгийн сонгуулийн саналын хуудсыг устгах ажлын хэсгийг байгуулж аймгийн архивт хадгалагдаж байгаа хадгалах хугацаа дууссан УИХ-ын сонгуулийн саналын хуудас 19 сумын 104 хэсгийн битүүмжлэл бүхий 88278 хуудас, орон нутгийн хурлын сонгуулийн 19 сумын 232 хадгаламжийн нэгж бүхий устгах бичгийн жагсаалтыг үйлдэж, устгах ажлын хэсэгт хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Архангай аймгийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталлаа.

Аймгийн Сонгуулийн хороо 4-р сарын сарын 22-ны өдөр хуралдан Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарь, жижүүрийн хуваарийг хэлэлцэж баталсан байна.

2020 оны 1-р улиралд иргэдээс аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд, агентлагуудад нийт 9468 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 9060 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй 354, харьяаллын дагуу 389 өргөдлийг холбогдох газруудад нь хандан шилжүүлсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93.1 хувьтай байна.

Нийт өргөдөлд хүсэлт 8620 буюу 91%, санал 223 буюу 2.4%, гомдол 625 буюу 6.6 хувийг тус тус эзэлж байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн “Шуурхай штаб”-ыг Засаг даргын Тамгын газарт ажиллуулж сум орон нутгийн мэдээллийг нэгтгэн улсын Онцгой комисс, хойд бүсийн төв, бусад холбогдох албан тушаалтнуудыг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд зориулан 4-р сарын 30-ны өдрийн байдлаар аймгийн Онцгой комисст нийт 47 иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас 44.4 сая төгрөгийн хандив цуглараад байна.

Улсын онцгой комиссын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/190 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан арга хэмжээ, спорт, урлагийн уралдаан, тэмцээн, хурал, зөвлөгөөн, интернет тоглоом, баар, караоке, хурдан морины уралдаан, спорт заал, сүм хийдийн үйл ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд сунгах арга хэмжээ авлаа.

4-р сарын 20-ны өдөр аймгийн Онцгой комисст цугларсан хандиваар коронавирусний халдвараас урьдчилан сэргийлэх болон голомтын халдваргүйжүүлэлт хийх зориулалтаар энгийн болон батарейгаар цэнэглэдэг халдваргүйтгэлийн бодис шүршигч 2 төрлийн 9 ширхэг автомаксыг ОБГ-т 5, Зооноз өвчин судлалын төвд 4-ийг хүлээлгэж өгсөн.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй- 2020" сарын аяныг 4-р сарын 01-нээс 30-ны хооронд Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан уриатай уялдуулан, дэлхийн улс оронд тархаад байгаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байран дахь хүчирхийлэл дарамтыг хориглох, "COVID-19" халдварын тархалтаас урьдчилан сэргийлж, ажилтны эрүүл мэндийг хамгаалъя уриан дор зохион байгууллаа.

Аяны хүрээнд ажил олгогч эздэд зориулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, соёл, зан үйлийг төлөвшүүлэх, ХАБЭА-н болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг сануулсан уриалга, зөвлөмж гарган сурталчилгааны ажлыг 19 сум, аж ахуй нэгж байгууллага бүр дээр зохион байгууллаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлтийн талаар

2020 оны 4-р сард улсын төсөвт 110790.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 160000.0 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 144.4 хувиар, орон нутгийн төсөвт 772267.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 772267.6 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдээр бүртгүүлсэн 12 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа явуулах хүсэлт ирүүлсэн 2 иргэнийг татвар төлөгчөөр бүртгэн цахим тайлангийн системд нэвтрэх нэр нууц үгийг олгосон. Борлуулалтын орлого нь 50.0 сая төгрөгт хүрсэн 2 аж ахуйн нэгжийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгэн, шинэ цахим тайлангийн системд 860 аж ахуйн нэгжийг нэвтрэлтийн нэгдсэн системд холболтыг хийлээ.

3-р сарын НӨАТ суутган төлөгчийн тайлангийн ирцийг 98.7 хувьтай хангуулж, тоон гарын үсэг авах, татварын тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, татварын төрлөөр бүртгүүлэх зэрэг татвар төлөгчөөс цахимаар ирүүлсэн 180 хүсэлтийг хүлээн авч тухай бүр нь шийдвэрлэж, 18001288 дугаарт болон 70332268 дугаарт хандсан 310 гаруй татвар төлөгчид, нэг цэгийн өрөөгөөр үйлчлүүлсэн 144 иргэнд заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх 2380.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтын урилгыг цахим системд байршуулж, 1268.0 сая төгрөгийн дахин тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

3500.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 тендер шалгаруулалтыг зохион байгуулан гэрээ байгуулах эрх олгож мэдэгдлүүдийг хүргүүлсэн.

Орон нутгийн өмчит 32 төсөвт байгууллагад 63.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 1 байгууллагад 191 нэр төрлийн 73 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон.

Санхүүгийн хяналтын чиглэлээр

Эрдэнэбулган сумын сургуулийн өмнөх боловсролын бүх байгууллагуудыг хамруулан хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчийн нийт 35 төрлийн актаар 43.4

сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож хариуцагчдаар төлүүлэх, 8.2 сая төгрөгийн дүн бүхий 6 албан шаардлагаар зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг чиглэлийг өгсөн. Нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах, илэрсэн зөрчлийг арилгуулахаар аудитор, улсын байцаагч нар гүйцэтгэлийн хяналтыг явуулсны зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролын байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлууд, илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаар “Дотоод аудиторын зөвлөмж” бэлтгэн аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт хүргүүлээ.

Аудит, хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн барагдуулалт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар 10 байгууллага, албан тушаалтантай холбоотой 43.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд албан тушаалтан тус бүрт холбогдох нэхэмжлэл гаргасан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа

Иргэний бүртгэлийн чиглэлээр

2020 îî 4-р ñàðûí 27-ны áàéäèààð äàðààð á¿ððäýèèééé ðèéæ ä¿éöýðäýéý.

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 210
- Гэрлэлтийн бүртгэл - 41
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 10
- Эцэг тогтоосны бүртгэл - 6
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 7
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 7
- Нас баралтын бүртгэл - 41
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 35
- Дахин олгосон – 43
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 82 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр

2020 îî 4-р ñàðûí 27-ны áàéäèààð íèèð èðäýí ðóòèèèí ýðäýýäýýñ 362 ìýä¿éäèééé ð¿éýýí äâ÷ äàðààð á¿ððäýèèééé ðèéæ ä¿éöýðäýéý.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 40
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 13
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 7
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 105
- Арилжааны гэрээ – 0
- Худалдах худалдан авах гэрээ – 43
- Бэлэглэлийн гэрээ – 5
- Барьцааны эрхийн бүртгэл – 206
- Өв залгамжлал – 11
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 1
- Лавлагаа – 3
- Бусад эрхийн бүртгэл – 10

Хóóèü öýíàèòûí áàéäóóèèäàäàá íèèð 52 èààèäàäàä äàðààí ð¿ðä¿¿èñýí áàéíà. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 2.824.470 тэмдэгтийн хураамжид

92051 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 6.450.000 төгрөгийг төвлөрүүлээ.

Хуулийн этгээдийн чиглэлээр

- Шинээр бүртгүүлсэн – 10
- Өөрчлөлт – 8
- Тамганы хяналтын дугаар олгосон –18 бүртгэл хийсэн.

2020 оны 4-р сард аймгийн хэмжээнд 14 удаагийн аюулт үзэгдэл техникийн холбогдолтой осол тохиолдосноос 5 удаагийн объектын гал түймэр, 2 удаагийн ой, хээрийн гал түймэр, 6 удаагийн мал, амьтны гоц халдварт өвчин, 1 удаагийн эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага гарч 1 өвөл зуны сууц, 2 гэр, 1 малын хашаа саравч нийт ард иргэдийн 59 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан байна.

“Орчны цэвэрлэгээ, сэг зэм устгах, халдваргүйтгэх шуурхай ажил зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар албан даалгавар, А/182 дугаар захирамжийн хүрээнд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, орон нутгийн хэмжээнд халдваргүйжүүлэлт хийх, ахуйн хог хаягдал цэвэрлэх, мал, амьтны сэг, зэм устгах ажлыг 3-р сарын 25-ны өдрөөс 4-р сарын 07-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгууллаа.

Дээрхи ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 424 байгууллагын 1.365.020 м гадна талбай, хур хог цугларсан газар, үерийн далан, сувгийн хог, хаягдлыг цэвэрлэж, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байгууламжийн 326.422 м.кв талбайд халдваргүйжүүлэлт хийж, 14772 мал амьтны сэг, зэмийг устгаж, нийт 41375 литр бодис ашиглаж, 11.7 сая төгрөгийг зарцуулсан.

Онцгой байдлын газраас шинэ короновирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд улс орон даяар зохион байгуулж буй “Маскаа зүүцгээе” аяныг өрнүүлж аймгийн төрийн болон хувийн хэвшлийн нийт 248 аж ахуй аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагч, түрээслэгч, томоохон зах худалдааны төвүүдээр үйлчүүлж буй иргэд нийт 10280 хүнд шинэ короновирусээс урьдчилан сэргийлэх, амны хаалт тогтмол зүүх, байгууллагуудыг амны хаалттай иргэдэд үйлчилгээ үзүүлэх талаар гарын авлага, зөвлөмж тараан ажилласан.

Мөн Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээллийг 19 сумын узель, чанга яригч, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын дуут дохиолол бүхий автомашинаар аймгийн төв, 1-7 дугаар багийн нутаг дэвсгэр дэхь орон сууцнууд, зах худалдааны төв, Цагаан даваа, Арслан цохио, Бор толгой, Наранбулаг, Тамир, Цаг уурын гудамж хорооллоор 6 удаагийн давтамжтайгаар автомашины чанга яригчаар аймгийн төвийн давхардсан тоогоор 130 мянга орчим иргэдэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж ажиллаж байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Үйлдвэрийн барилга байгууламж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг, импортоддог аж ахуй нэгжид” тус тус төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Үйлдвэрийн барилга байгууламжийн шалгалтаар нийт 8 байгууллагын 9 объект хамрагдаж, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 72 зөрчил илрүүлж, 25 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал

түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, мэдэгдэл 3-ийг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

Газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг, импортолдог аж ахуй нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалтаар нийт 5 байгууллагын 7 шатахуун түгээх станцад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 38 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах тодорхой ажил зохион байгуулах тухай гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 2, мэдэгдэл 5-ийг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан болон иргэнд хүргүүлж нийт 30 зөрчлийг бүрэн арилгуулсан байна.

Шүүхийн шинжилгээний алба 4-р сард криминалистикийн шинжилгээ 6, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 54, шүүх эмнэлгийн шинжилгээ 49, тусгай шинжилгээ 18-г тус тус хийсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2150589.8 төгрөгийн мөнгөн дүн бүхий 415 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 27.1, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 15.1 байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 4 сумын 22 аж ахуйн нэгжид хяналт шалгалт, 10 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ, 9 аж ахуйн нэгж, 30 малчин өрхөд тандалт судалгаа, 6 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 2 хяналт шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтын явцад 169 алдаа дутагдал илрүүлж улсын байцаагчийн 18 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар, 6 зөвлөмж өгч биелэлтэд хяналт тавьж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 01/13 дугаар удирдамж, аймгийн Засаг даргын 2020 оны А/134 дүгээр захирамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Эрдэнэбулган сумын хүнсний худалдааны цэгүүдэд 4-р сарын 13-ны өдөр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, улсын байцаагчийн 22 актаар нийт 280 нэр төрлийн 2719 ширхэг, 106.9 кг хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, 6 сая 326.101 төгрөгийн хадгалах хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй хүнсний бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээг зохион байгуулан, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцсон байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсролын чиглэлээр

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлийг 2-р сарын 15-ны өдрөөс 4-р сарын 15-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг зохион байгууллаа. Архангай аймагт 2019-2020 оны хичээлийн жилд танхимын сургалтаар 997 сурагч, дүйцсэн хөтөлбөрийн ангиллаар 67 сурагч 12-р ангийг тус тус төгсөнө. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр 976 сурагч онлайнаар бүртгүүлж, бүртгэлээ баталгаажуулсан байна. Эдгээр сурагчид ЭЭШ-ийн 10 хичээлээс 2-7 хичээлийг сонгож бүртгэлээ баталгаажуулсан бөгөөд давхардсан тоогоор 2957 сурагч элсэлтийн ерөнхий шалгалт өгнө.

БСШУСЯ-наас 12-р анги төгсөх сурагчдын тоогоор ЭЭШ-ын зөвлөмж, “СД” ирүүлсэн бөгөөд хүүхэд бүрт хүргэх ажлыг сургууль, багш нартай хамтран зохион байгуулсан.

“Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын

2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар батлагдсан “Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын түр журам”-ыг Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгүүд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Соёл урлагийн чиглэлээр

Хорио цээрийн дэглэм тогтоож, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, үзвэр үйлчилгээг зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан аймгийн Нийтийн номын сан, Хөгжимт драмын театр, Музей иргэд олон нийтэд чиглэсэн урлаг, соёлын үйлчилгээг цахимаар болон зайнаас зохион байгуулж байна. Тухайлбал:

Нийтийн номын сангийн гэрээр ном олгох үйлчилгээгээр үндсэн фонд, нийтийн болон хүүхдийн уншлагын танхимаар нийт 10 уншигч шинээр бүртгэж, 60 ирэгсэдэд 80 ширхэг сонин 41 номыг олгож, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр төрийн 15 байгууллагын 110 ирэгсэдэд 325 номоор үйлчилсэн бол аймгийн Музей “Заяын хүрээний үүсэл, хөгжил”, Зая гэгээн Жамбацэрэнгийн хэрэглэж байсан “Таван саваагүй” зэрэг үзмэрүүдийн мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудас, “Монцамэ агентлаг”, “Архангай амьдрал сонин”, “Архангай сэтгүүл” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж байна.

Хөгжимт драмын театр орон нутгийн “АВ” телевизтэй хамтран “Амьдрал тэтгэгч”, “Шидэт шүүр” жүжгүүд, “Бидний дуулал” шинэ уран бүтээлийн концерт зэрэг уран бүтээлийг дүрсжүүлэн бичлэг хийж бүх насны үзэгчдийн хүртээл болгоход бэлэн болгосон байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

Гадаад улс ороноос ирж, Улаанбаатар, Дархан, Орхон, Увс аймагт тусгаарлагдаж байгаад гэрийн тусгаарлалтад шилжсэн 7 иргэнийг харъяа сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн байдлыг нь тандаж, 6 иргэний гэрийн тусгаарлалт дуусч, 1 иргэнийг хяналтад байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад анги даасан багш нараар дамжуулан коронавируст халдвараас сэргийлэх зөвлөгөө мэдээлэл хүргэх 14 хоногийн сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн Боловсрол соёл урлагийн газраар дамжуулан бүх ерөнхий боловсролын сургуулиудад сурталчилгааны удирдамж, материалуудыг цахимаар хүргүүлсэн.

Улаанбаатараас Архангай аймгийн Эрдэнэбулган, Чулуут, Тариат, Цахир, Ихтамир сумын чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн 104 автобусны 3016 зорчигчийн биеийн халууныг үзэж, тэмдэглэл хөтлөн тандалт хийсэн. Биеийн халуун нэмэгдсэн хүн байхгүй байна.

Шинэ коронавирусын халдварын бэлэн байдлыг хангахад чиглэсэн сургалтыг 4 удаа онлайн хэлбэрээр зохион байгуулж нийт 680 гаруй эмнэлгийн ажилчдыг хамруулсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2020 оны 4-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 985 иргэн бүртгэлтэй байгаагаас 504 эмэгтэй. Шинэ ажлын байр 97 үүнээс байнгын ажлын байр 65, улирлын ажлын байр 3, түр ажлын байр 29 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 83, зуучлал 72 байна.

4-р сарын 20-ны байдлаар 37 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал:

боловсролгүй-8, бага-23, суурь-148, бүрэн дунд- 602, техникийн болон мэргэжлийн анхан шатны –21, тусгай мэргэжлийн дунд-17, Дипломын бакалаврын-166 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 25 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХ-т хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлж орлогын эх үүсвэртэй болгох бүлгийн төслийг зарлан хүнсний ногоо, гар урлал, сүү цагаан идээ, оёдол, гутал засвар, үсчин, арьсан эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нийт 11 сумын 15 төслийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Бүлгийн төсөлд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 31 өрхийн 31 иргэн хамрагдаж байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 4-р сарын 25-ны байдлаар нийт 5313.8 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 109 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 13.8 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 15.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1787.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 5313.8 сая төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 850.9 сая төгрөгөөр өссөн. Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

- Тэтгэврийн даатгалын санд 65.5 % буюу 3485.7 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 7.3 % буюу 391.8 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 5.6 % буюу 298.3 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.5 % буюу 84.7 сая төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 20.1 % буюу 1053.1 сая төгрөг

2020 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 16.3 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 2.24 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Аймгийн хэмжээнд 2.053.2 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 2020 оны 4-р сарын 29-ний байдлаар 1576980 мянган толгой мал төллөсөн байна. Үүнд: Ингэ 175 буюу 58.2 хувь, Гүү 19132 буюу 19.8 хувь, Үнээ 10517 буюу 61.2 хувь, Эм хонь 1028337 буюу 86.4 хувь, Эм ямаа 42.3 буюу 71.3 хувь төллөж аймгийн дүнгээр бод малын 46.3 хувь, бог малын 81.3 хувь ба нийт мал төллөлт 76.6 хувьтай байна. 1358381 мянган толгой төл 86.6 хувьтай бойжиж байна.

Том малын зүй бус хорогдол 249.2 мянган толгой мал буюу нийт малын 4.0 хувь нь хорогдсон байна.

Байгаль орчинд халгүй энгийн механик аргаар 8 сумын 70000 га талбайд, микробиологийн аргаар 5 сумын 25000 га талбайд бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгчид, үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газар, сумдын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгууллаа.

4-р сарын сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 90.5 тн буюу 8 хоног, гурил 243.1 тн буюу 32 хоног, гоймон 21.6 тн буюу 2 хоног, будаа 78.7 тн буюу 21 хоног, сахар 44.8 тн буюу 18 хоног, ургамлын тос 17 тн буюу 10 хоног, давс 20 тн буюу 50 хоног, ундны ус

25.9 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 3.02 тн буюу 3 хоног, төмс 36.2 тн буюу 13 хоног, хүнсний ногоо 20 тн буюу 2 хоног, өндөг 0.96 тн буюу 1 хоногийн нөөцтэй байна.

Энэ онд Архангай аймгийн хэмжээнд 12644 га талбайд улаан буудай тариалах бөгөөд үүнээс механик уриншид 8375 га-д, химийн уриншид 2425 га-д, гуурсанд 1594 га-д, бусад таримлын өмнөгчид 250 га-д тариална. Тариалалтад шаардагдах нийт үрийн хэмжээ 2149 тн бөгөөд 690 тн үрийн нөөцтэй тул 1459 тн үр Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авах шаардлагатай байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Сум дундын ойн ангиас ойн сан бүхий сумдын Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, ард иргэд, ойн нөхөрлөлүүдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага тарааж, Тариат, Өндөр-Улаан, Чулуут сумдын 2020 оны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудыг үндэслэн аж ахуй нэгж, ойн нөхөрлөлүүдийн талбай тусгаарлалтын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллалаа.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

2020 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэлэлцэж баталсантай холбогдуулан аймгийн төвийн болон 18 сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг www.arkhangai.gov.mn цахим хуудсанд байрлуулсан.